

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2016 ОНЫ
02 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2016 оны 03 дугаар сарын 09


Дуурсах

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

Тус Цагдаагийн газар нь 2016 оны 02 дугаар сард

- Нийт 687 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 20 нэгжээр буюу 3 хувиар өссөн байна.
- 190 буюу 27 хувийг гэмт хэргийн шинжтэй,
- 339 буюу 49 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл
- Үлдэгдэл 58 гомдол, мэдээлэл шалгасан.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй 190 гомдол, мэдээллийн 60 буюу 31 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 130 буюу 68 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлсэн.



Захиргааны зөрчлийн 339 гомдол, мэдээллийн:


- 93 буюу 27 хувийг торгуулийн хуудсаар,
- 210 буюу 61 хувийг шийтгэврээр торгох,
- 10 буюу 2 хувийг баривчлах,
- 67 буюу 19 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан.

Хоёр. Гэмт хэргийн байдал


Аймгийн хэмжээнд 2016 оны 02 дугаар сард 63 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэгжээр буюу 25 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 41 буюу 65 хувь нь Баянхонгор суманд, 22 буюу 34 хувь нь бусад суманд үйлдэгдсэн.

Баянхонгор сумын багуудад гарсан гэмт хэрэг




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



2. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

- Хөнгөн ангиллын гэмт хэрэг 35 бүртгэгдэж 4 нэгжээр буюу 10 хувиар өссөн,
- Хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 24 бүртгэгдэж -14 нэгжээр буюу -36 хувиар буурсан,
- Хүнд ангиллын гэмт хэрэг 1 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 75 хувиар,

- Онц хүнд ангиллын гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд байна.



3. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг:

23 хэрэг бүртгэгдснээс 9 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон. Одоо бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй бусдын эд хөрөнгийг хулгайлах 14 гэмт хэрэг, үүнээс 5 нь мал хулгайлах хэрэг байна.

4. Гэмт хэргийн илрүүлэлт:

- Нийт хэргийн илрүүлэлт 39,1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9,1 пунктээр өссөн.
- Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 22,2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн 22,2 пунктээр өссөн,
- Хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 46,2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13,8 пунктээр буурсан,
- Хүнд гэмт хэргийн илрүүлэлт 100 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 100 пунктээр хувиар өссөн,
- Онц хүнд эзэнгүй хэрэг бүртгэгдээгүй.


5. Бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл:

| Нийт хэрэг | 2015 оны 02 сар | 2016 оны 02 сар | Харьцуулалт | |
|-----------------------------|--------------------|--------------------|-------------|---------|
| | | | Тоо | Хувь |
| Хүн амь | 1 | 3 | 2 | 2 дахин |
| ББМБГУ | 35 | 24 | -11 | -31% |
| Хүчиндэх | 2 | 0 | -2 | -100% |
| Бусдын эд хөрөнгө хулгайлах | 24 | 27 | 3 | 13% |

8. Гэмт хэргийн улмаас 67 иргэн хохирсон: 30 хүн гэмтэж, 3 хүн нас барсан байна.

- 72,5 сая төгрөгийн хохирол учирснаас 45,6 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 62 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлэлт /сая төгрөг/



Гурав. Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт

Аймгийн хэмжээнд 2016 оны 02 дугаар сард 1277 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 739 нэгжээр буюу 36 хувиар буурсан.

- 12 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 60 нэгжээр буюу -83 хувиар буурсан,
- 75 зөрчлийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, торгосон байна.
- 955 зөрчлийг торгуулийн хуудсаар 24402,0 мянган төгрөгөөр,
- 322 зөрчлийг шийтгэврээр 40169,0 мянган төгрөгөөр торгосон.
- 302 хүн саатуулж, 888,1 мянган төгрөгийн хураамж төлүүлж ажилласан.

ДҮГНЭЛТ

2016 оны 02 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 63 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэгжээр буюу 25 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлт 39,1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9,1 пунктээр өссөн. Хэргийн гаралт 9 суманд буурч, 6 суманд өсөж, 3 суманд ижил түвшинд байна. Хүчин 2 нэгжээр буюу 100 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 11 нэгжээр буюу 31 хувь, малын хулгай 3 нэгжээр буюу 25

хувь, Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8 нэгжээр буюу 100 хувь, бусад гэмт хэрэг 5 нэгжээр буюу 45 хувь тус тус буурсан.

Харин хүн амь 2 нэгжээр буюу 2 дахин, өмчийн хулгай 3 нэгжээр буюу 13 хувь, иргэдийн өмчийн хулгай 5 нэгжээр буюу 56 хувь, дээрэм 1 нэгжээр буюу 100 хувь өссөн байна.

Нийт бүртгэгдсэн 63 гэмт хэргийн 13 буюу 20 хувь нь “Даваа” гарагт, 25 буюу 39 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**